

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2023.04.24.

№ 23/01

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.7 дэх заалт, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон “Богд Банк” ХК-ийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, тус тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2 тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Богд Банк” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланд ТУЗ-өөс өгсөн “хангалттай сайн” гэх дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.
2. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2023.04.24.

№ 23/02

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлантай танилцаж
ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.6 дэх заалт, “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.8 дахь заалтуудыг тус тус удирдлага болгон “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны жилийн үйл ажиллагааны тайлантай танилцаж, хэлэлцсэний үндсэн дээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2 тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Богд Банк” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж ТУЗ-н 2023 оны зардлын төсвийг Хавсралт-1-н дагуу баталсугай.
2. Энэхүү ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж нийтэд мэдээлэхийг “Богд Банк” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны
01 дүгээр сарын 21-ний өдрийн
23/22 тоот шийдвэрийн Хавсралт 1



2023 оны зардлын төсөв /ТУЗ/

/мянган төгрөгөөр/

д/д	Зардлын ангилал	2023 оны 5 сараас -2024 оны 4 сар /жилийн дүн/
НИЙТ ТӨСӨВ /ЗАРДАЛ + ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ/		291,127.5
1	Нийт зардлын төсөв. Үүнээс:	291,127.5
	1 Цалин хөлс түүнтэй холбоотой зардал	291,127.5
	2 Ашиглалтын зардал	-
	3 Бичиг хэрэг, хангамжийн материалын зардал	-
	4 Харилцаа холбооны зардал	-
	5 Автомашин түүнтэй холбоотой зардал	-
	6 Томилолт, зочны зардал	-
	7 Үйл ажиллагааны бусад зардал	-
	8 Зочин төлөөлөгч баяр ёслолын зардал	-
2	Хөрөнгө оруулалтын төсвийн нийт дүн	-
	1 Техник, тоног төхөөрөмж	-

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

Огноо: 2023.07.24

№ 23/03

Улаанбаатар хот

Компанийн ТУЗ-ийн гишүүнийг шинээр сонгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7 дэх хэсэг, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.9 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.8 болон “Богд Банк” ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.8.1 дэх хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 2023 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2 тоот шийдвэр зэргийг үндэслэн Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаас ШИЙДВЭРЛЭХ нь:

1. “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Аукланд Эллиот нь чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул бүхэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгосугай.
2. Чөлөөлөгдсөн “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний оронд “Богд Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Рэнцэндорж овогтой Баясгаланг 3 жилийн хугацаатайгаар сонгож томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.БОЛДХУЯГ